



**ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ,
БИЗНЕСИЙН “АРМОНО КОРПОРАЦИ” ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/23/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг:

Ахлах аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг:

“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн захирал Б.Осоргарав
Утас: 70110744 Цахим хаяг:

ЧХХД, партнер Н.Эрдэнэцог
Утас: 70110744 Цахим хаяг:

Аудитор Л.Пунсал-Орлом
Утас: 88054775 Цахим хаяг: punsal-orkom.l@mn.gt.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	8
2	Аудитын тайлан	9
2.1	Оршил.....	9
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	9
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	10
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	11
2.5	Дотоод хяналт.....	11
2.6	Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга	11
2.7	Шилэн дансны мэдээлэл	12
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	12
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	12
2.9.1	Үндсэн хөрөнгийн талаар	12
2.9.2	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	12
2.9.3	Орлого, зардлын талаар.....	12
2.9.4	Урьдчилж төлсөн зардлын талаар	13
2.9.5	Мөнгөн хөрөнгийн талаар.....	13
2.9.6	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	13
2.9.7	Авлага, өглөгийн талаар.....	13
2.9.8	НББ-ийн програм хангамжийн талаар.....	13
2.9.9	Үндсэн хөрөнгийн талаар	14
2.9.10	Санхүүгийн тайлангийн талаар.....	14
2.9.11	Орлогын талаар	14
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	14
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	15
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	15
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	15
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3	Менежментийн захидал	16
3.1	Үндсэн хөрөнгийн талаар.....	17
3.2	Мөнгөн хөрөнгийн талаар	18
3.3	Авлага, өглөгийн талаар	19
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	20
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	20
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	21
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	23





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/718
танай _____-ны № _____-т

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
“АРМОНО КОРПОРАЦИ” ТӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ П.НАСАНЖАРГАЛ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_KhereglYawsan_Bichig\2018\0315SAG46.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


Үүрэг, хариуцлага

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.


Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_KheregYavsen_Bichig\2018\0315\1616 Doc





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 дугаар сарын 15

№ 01/61

Улаанбаатар хот

САГ-12018/23/СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хуульд заасан хугацаанаас 10 хоног хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж...” гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх...” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланг хоцроосон холбогдох ажилтанд хариуцлага тооцож, санхүүгийн тайланг хуулиар тогтоосон хугацаанд Үндэсний аудитын газарт хүргүүлж байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал, нягтлан бодогч Ц.Ичинхорлоо нарт үүрэг болгосугай.


АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
Д.ЦЭГМИДДОРЖ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:
“УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ”
ХХК-ИЙН АУДИТОР
Л.ПУНСАЛ-ОРЛОМ

ЗӨВШӨӨРСӨН:
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
“АРМОНО КОРПОРАЦИ” ТӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ
П.НАСАНЖАРГАЛ
НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ИЧИНХОРЛОО



Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтны үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



\\10.10.10.20\Bichig_Kherel\Alban.Shaardlaga\2018\03\15\SAG3.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 дугаар сарын 15

№ 01/62

Улаанбаатар хот

САГ-12018/23/СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар үндсэн хөрөнгийн түүвэр тооллого хийхэд тус ТӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 3,643,200.00 төгрөгийн өртөгтэй модон байшин биетээр оршин байхгүй, үндсэн хөрөнгийн тооллогоор дутагдаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.” мөн хуулийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх...” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй дээрх биетээр байхгүй 3,643,200.00 төгрөгийн хөрөнгийг олж аван, холбогдох арга хэмжээ авч, шийдвэрлүүлэх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал, нягтлан бодогч Ц.Ичинхорлоо нарт үүрэг болгосугай.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Д.ЦЭГМИДДОРЖ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:
“УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ”
ХХК-ИЙН АУДИТОР
Л.ПУНСАЛ-ОРЛОМ

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
“АРМОНО КОРПОРАЦИ” ТӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ
П.НАСАНЖАРГАЛ
НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ИЧИНХОРЛОО

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28-дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн албан тушаалтанд харилуулага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 дугаар сарын 15

№ 01/63

Улаанбаатар хот

САГ-2018/23/СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн "Армоно корпораци" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус ТӨААТҮГ нь төрийн өмчийг хуулийн этгээд, иргэнд түрээслүүлснээр түрээсийн орлого 230.7 сая төгрөг олноос ашиглалтын зардалд 62.1 сая төгрөг, ажилчдын цалингийн зардалд 159.2 сая төгрөгийг тус тус төлж жилийн эцсээр нийт 110,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаас түрээсийн орлогын улсын төсөвт төвлөрүүлэх 69.2 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т "Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх..." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус ТӨААТҮГ нь өөрийн үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх тал дээр анхаарч, цаашид ТӨБЗГ-ын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т заасныг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн "Армоно корпораци" ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал, нягтлан бодогч Ц.Ичинхорлоо нарт үүрэг болгосугай.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Д.ЦЭГМИДДОРЖ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:
"УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ"
ХХК-ИЙН АУДИТОР
Л.ПУНСАЛ-ОРЛОМ

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА,
ТУРШИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН
"АРМОНО КОРПОРАЦИ" ТӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

П.НАСАНЖАРГАЛ
НЯГТЛАН БОДОГЧ
Ц.ИЧИНХОРЛОО

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу зөрчил албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Alban_Shaardlaga\2018\0316\SAAG6_Docx

1 Аудитын гэрчилгээ

Үүрэг, хариуцлага

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч П.Насанжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, орлогын талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл бүрэн байх, өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2018/23/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-т хүргүүлэхээр төлөвлөн, “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн аудитор Л.Пунсал-Орлом, аудиторын туслах Т.Отгоннаран нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдөр “Улаанбаатар аудит корпораци” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Эрдэм шинжилгээний байгууллагуудын үндсэн хөрөнгө дэд бүтцийг хэвээр хадгалан чиг үүргийн дагуу ашиглуулах, хөнгөн үйлдвэрийн судалгаа туршилт үйлдвэрлэл, бизнесийн корпорацийг БСШУ-ны яамны харъяа аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсугай” гэж заасны дагуу аж ахуйн тооцоотой үйл ажиллагаа явуулах болсон байна.

Байгууллагын эрхэм зорилго:

Тус корпораци арьс ширний үйлдвэрлэлийг Монгол Улсын хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх салбарын нэг болгоход чиглэгдсэн шинжлэх ухаан, инновацид суурилсан, байгаль орчинд халгүй технологийн хөгжлийг хангах зорилготой байна.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын -ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл:


- ❖ Хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын хүрээнд хэрэгцээтэй, шийдвэрлэх асуудлаар цөм технологи, шинжлэх ухаан технологи, инновацийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;
- ❖ Шинжлэх ухааны болон үйлдвэрлэл технологийн паркийг хөгжүүлэх ажилд оролцох;
- ❖ Арьс ширний салбарын өндөр технологийн аргуудыг өөрийн орны онцлогт тохируулан зохистойгоор сонгон судлах, инновацилах;
- ❖ Салбарын тулгамдсан асуудлаар эрдэм, шинжилгээний бага хурал, семинар зохион байгуулах;
- ❖ Хөнгөн үйлдвэрийн салбарт төрөөс баримтлах бодлого, стратеги боловсруулахад мэргэжлийн байгууллагын зүгээс санал боловсруулж оролцох;
- ❖ Арьс ширний салбарын техникийн баримт бичиг, стандарт боловсруулах, шинэчлэн сайжруулахад манлайлан оролцох;

Үйл ажиллагааны стратегийн зорилт

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ нь “Хөнгөн үйлдвэрийн салбарт био нано өндөр технологи болон инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дамжуулах тус салбарт эрдэм шинжилгээ судалгаа туршилт зохион бүтээх ажил, зөвлөх үйлчилгээг үзүүлэх, мэргэжлийн хүний нөөц бэлтгэх, сургалт зохион байгуулах” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Арьс шир, үслэг боловсруулах байгаль орчинд халгүй технологийн судалгааг нутагшуулах.
- Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж болон хөрөнгө оруулалтын төсөл



боловсруулах, зөвлөх үйлчилгээ.

- Арьс ширний салбарын стандарт боловсруулах, батлуулах.
- Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ.
- Арьс шир, үслэг боловсруулах үслэг боловсруулах үйлдвэрүүдийн химийн болон туслах материалын судалгаа, сонголт.
- Арьс шир үслэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
- Мэргэжлийн инженер техникийн ажилтнуудын сургалт явуулах зэрэг болно.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 10 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 33 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “covor soft” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт


Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт нь лабораторийн үйл ажиллагааны бүх түвшинд хангалттай, харин санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул гэж үзлээ.

2.6 Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

Тус ТӨҮГ нь 2017 оны бизнес төлөвлөгөөгөөр тайлант оны орлогыг 348.7 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 398.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Тайлант оны орлогын гүйцэтгэл 341.3 сая төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 345.6 сая төгрөг байна.



Батлагдсан орлогын төлөвлөгөөний биелэлт 97.9 хувь буюу 7.4 сая төгрөгөөр тасарсан, үйл ажиллагааны зардлын биелэлт 86.7 хувь буюу 53.2 сая төгрөгийг хэмнэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар болон тухай бүр оруулах мэдээллийг оруулаагүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 33 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

- Төслийн санхүүжилтээр бэлтгэсэн 6.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.
- Төслийн санхүүжилтээр бэлтгэсэн уг хөрөнгөнд 0.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Энэ нь 2016 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн SHUTT-004/2015 тоот Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний 1.8-д “Төслийн зардлаар бий болсон үндсэн хөрөнгө /багаж, төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютер гэх мэт/-ийг төсөл дууссанаас хойш ХҮСҮТҮБ-ийн Армоно нэгдлийн өмчид бүртгэж ашиглана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудит хийгдэх хугацаанд 6.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг залруулж бүртгэлд тусгах.

2.9.2 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар


- Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгөнд тайлант онд 0.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 0.1 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна.

Энэ нь НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” стандарттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудит хийгдэх хугацаанд үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой 0.7 сая төгрөгийн алдааг залруулах.

2.9.3 Орлого, зардлын талаар

- Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 17.0 сая төгрөгөөр, орлогыг 1.4 сая төгрөгөөр тус тус дутуу буюу зөрүүтэй тайлагнасан байна.
- Орлогын дэлгэрэнгүй тайланд тайлант оны орлогыг 22.1 сая төгрөгөөр дутуу тусгаж тайлагнасан байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудит хийгдэх хугацаанд 40.5 сая төгрөгийн алдааг залруулах.

2.9.4 Урьдчилж төлсөн зардлын талаар

Тайлант онд 5.6 сая төгрөгөөр Урьдчилж төлсөн зардал дансыг бууруулсан байна.

Энэ нь 2016 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн SHUTT-004/2015 тоот Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний 1.8-д “Төслийн зардлаар бий болсон үндсэн хөрөнгө /багаж, төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютер гэх мэт/-ийг төсөл дууссанаас хойш ХҮСҮТҮБ-ийн Армоно нэгдлийн өмчид бүртгэж ашиглана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудит хийгдэх хугацаанд 5.6 сая төгрөгийн алдааг залруулах.

2.9.5 Мөнгөн хөрөнгийн талаар

Тайлант хугацаанд 5.3 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

2.9.6 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20 нэр төрлийн 30.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглаж байна.

Энэ нь НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” стандарттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 онд Сангийн сайдын үндсэн хөрөнгө дахин үнэлэх шийдвэрийн дагуу дахин үнэлж, эдийн засгийн ашиглалтын хугацааг тооцож, бүртгэлд тусгах, цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг зохих зөвшөөрлийн дагуу данснаас хасах талаар зөвлөмж өгөх.

2.9.7 Авлага, өглөгийн талаар

Тайланд онд жилийн эцсээр 12.8 сая төгрөгийн авлага тайлагнаснаас 6.1 сая төгрөгийн авлагыг, мөн 93.4 сая төгрөгийн өглөгийг тайлагнаснаас 33.6 сая төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.


Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-г мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

2.9.8 НББ-ийн програм хангамжийн талаар

Тус ТӨААТҮГ нь санхүүгийн “Povor soft” програмыг ашиглаж байгаа боловч уг програмаас санхүүгийн тайлан, журналууд бүрэн гүйцэд боловсруулагдан гардаггүй нь НББ-ийн шаардлагад нийцэхгүй байна.

САГ-2018/23/СТА-ТӨҮГ



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн шаардлагад нийцсэн програм хангамж ашиглах талаар зөвлөмж өгөх.

2.9.9 Үндсэн хөрөнгийн талаар

Аудитаар тус ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд түүвэр тооллого хийхэд 3,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө /модон байшин/ биетээр оршин байхгүй, тооллогоор дутагдаж байна.

Энэ нь Санхүүгийн тайлангийн “Оршин байх, Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэл болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.”, мөн хуулийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Биетээр оршин байхгүй 3.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн талаар албан шаардлага өгөх.

2.9.10 Санхүүгийн тайлангийн талаар

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанаас 10 хоног хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж,...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хоцроосон холбогдох ажилтанд хариуцлага тооцож, санхүүгийн тайланг хуулиар тогтоосон хугацаанд Үндэсний аудитын газарт хүргүүлж байх талаар албан шаардлага өгөх.

2.9.11 Орлогын талаар

Тайлант онд тус ТӨААТҮГ нь төрийн өмчийг хуулийн этгээд, иргэнд түрээслүүлснээр түрээсийн орлого 230.7 сая төгрөг олсноос ашиглалтын зардалд 62.1 сая төгрөг, ажилчдын цалингийн зардалд 159.2 сая төгрөгийг тус тус төлж жилийн эцсээр нийт 110,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаас түрээсийн орлогын улсын төсөвт төвлөрүүлэх 69.2 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тус ТӨААТҮГ нь өөрийн үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх тал дээр анхаарч, цаашид ТӨБЗГ-ын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т заасныг мөрдөж ажиллах албан шаардлага өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.



2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад төлөвлөсөн дансдад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11 төрлийн 201.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 5 төрлийн 53.6 сая төгрөгийн алдааг залруулж, 3 төрлийн 75,1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 3 төрлийн 72.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага тус тус өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгов.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 345.7 сая төгрөг бөгөөд 2 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.ОСОРГАРАВ ОГНОО:

ЧХХД, ПАРТНЕР

Н.ЭРДЭНЭЦОГ ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДЭЛГЭРМАА ОГНОО:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Л.ПУНСАЛ ОРЛОМ ОГНОО:



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20 нэр төрлийн 30.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглаж байна.

Энэ нь НББОУС-16 “*Үндсэн хөрөнгө*” стандарттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль, журам, стандарт хэрэгжихгүй байх.
/ҮЗ, ЭҮ,ОБ/

ҮАГ-ын зөвлөмж

2018 онд Сангийн сайдын үндсэн хөрөнгө дахин үнэлэх шийдвэрийн дагуу дахин үнэлж, эдийн засгийн ажиглалтын хугацааг тооцож, бүртгэлд тусгах, цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг зохих зөвшөөрлийн дагуу данснаас хасах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.2 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд 5.3 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль, журам, стандарт хэрэгжихгүй байх.
/ҮЗ, ЭҮ,/

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.3 Авлага, өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тайланд онд жилийн эцсээр 12.8 сая төгрөгийн авлага тайлагнаснаас 6.1 сая төгрөгийн авлагыг, мөн 93.4 сая төгрөгийн өглөгийг тайлагнаснаас 33.6 сая төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хууль, журам, стандарт хэрэгжихгүй байх.
/ҮЗ, ЭҮ, /

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-г мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
		Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	11,471,516.38	2,459,300.10
Дансны авлага	27,852,225.00	12,813,670.00
Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
Бусад авлага	110,000.00	0.00
Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
Бараа материал	4,136,295.34	7,934,263.18
Урьдчилж төлсөн зардал тооцоо	22,637,458.66	83,455,542.01
Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	66,207,495.38	106,662,775.29
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,232,044,394.45	1,148,189,098.32
Биет бус хөрөнгө	980,540.61	882,486.61
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,233,024,935.06	1,149,071,584.93
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,299,232,430.44	1,255,734,360.22
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	45,172,000.95	33,576,474.78
Цалингийн өглөг	18,607.91	0.00
Татварын өр	47,069,251.17	58,376,163.84
НДШ-ийн өглөг	3,703,074.23	1,391,167.64
Урьдчилж орсон орлого	71,775,000.00	141,322,500.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	167,737,934.26	234,666,306.26
Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
Өр төлбөрийн нийт дүн	167,737,934.26	234,666,306.26
Эздийн өмч		
Өмч; Төрийн өмч	122,037,243.10	122,037,243.10
Хувийн өмч	0.00	0.00
Хувьцаат	0.00	0.00
Нэмж төлөгдсөн капитал	1,977,140,151.25	307,921,881.30
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	1,669,218,270.00
Эздийн өмчийн бусад хэсэг	100,931,461.00	100,931,461.00
Хуримтлагдсан ашиг	-1,068,614,359.17	-179,040,804.44
Эздийн өмчийн дүн	1,131,494,496.18	1,021,068,053.96
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,299,232,430.44	1,255,734,360.22

ТӨРИЙН АУДИТЧИН АЖИЛАА
ЗӨРЧИЛҮҮН
САНАЛ ДУНГУУЛТ

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2016 оны 12-р сарын 31 өдөр	2017 оны 12-р сарын 31 өдөр
Борлуулалтын орлого (цэвэр)	75,598,402.70	18,963,809.11
Борлуулалтын өртөг	42,877,062.41	25,012,861.13
Нийт ашиг (алдагдал)	32,721,340.29	-6,049,052.02
Нийт орлого		271,728,506.67
Түрээсийн орлого	261,633,776.94	230,665,802.56
Борлуулалтын орлого		18,963,809.11
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	3,512,320.00	22,098,895.00
НИЙТ ЗАРДАЛ		382,154,948.94
Ерөнхий ба удирдлагын зардал	358,745,478.59	251,180,054.15
Элэгдлийн зардал		84,979,691.74
Санхүүгийн зардал		
Бусад зардал	2,494,222.73	45,995,203.05
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-63,372,264.09	-110,426,442.27
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	-102,357,528.88	-110,426,442.27
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-110,426,442.27
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн		
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		0.00



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/


Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	122,037,243.10	307,921,881.30	1,669,218,270.00	100931461	(1,068,614,359.17)	1,030,563,035.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааы залруулга						-
Залруулсан үлдэгдэл			0.00	0.00		
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал/			0.00	0.00		
Бусад дэлэрэнгүй орлого						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			0.00	0.00	0.00	0.00
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	122,037,243.10	307,921,881.30	1,669,218,270.00	100,931,461.00	(1,068,614,359.17)	1,131,494,496.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл						
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/					-110,426,442.27	-110,426,442.27
Бусад дэлгэрээгүй орлого						
Өмчит гарсан өөрчлөлт						-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			0.00	0.00	0.00	0.00
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	122,037,243.10	307,921,881.30	1,669,218,270.00	100,931,461.00	-1,179,040,801.44	1,021,068,053.96



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31 өдөр	2017 оны 12-р сарын 31 өдөр
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	368,330,455.00	343,478,429.67
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого		
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	20,030,070.00	18,963,809.11
Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө	239,419,000.00	230,665,802.56
Нийгмийн даатгалын сангаас	2,043,260.00	2,202,423.00
Буцаан авсан албан татвар	0	0
Төслийн санхүүжилтийн орлого	91,575,000.00	69,547,500.00
Бусад мөнгөн орлого	15,263,125.00	22,098,895.00
Мөнгөн зарлагын дүн (-)	297,351,049.72	345,592,363.95
Ажиллагчдад төлсөн	121,613,017.03	129,019,459.20
Төслийн цалин		13,530,000.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,056,560.00	36,589,326.00
Бараа материал худалдан авахад төлсөн	56,101,300.09	40,986,161.25
Ашиглалтын зардалд төлсөн/гэрэл, дулаан, ус/ Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	73,291,552.60	62,050,272.62
5,058,300.00	1,856,693.80	
Шуудан холбооны зардал		3,680,321.80
Урсгал засварын зардал		3,266,073.80
Сэлбэг хэрэгслийн зардал		3,252,210.11
Шагнал урамшууллын зардал		159,000.00
Хөдөлмөр хамгааллын зардал		1,538,420.00
Бичиг хэргийн зардал		751,014.52
Банкны шимтгэл		29,900.00
Буцалтгүй тусламж		1,236,000.00
Бусад зардал		4,822,428.74
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал		1,150,000.00
Харуул хамгаалалтын зардал		12,100,000.00
АТӨЯТХ-ийн татварт төлсөн		256,600.00
Бусад татварт төлсөн		1,624,120.00
ХАОАТ-т төлсөн		8,335,349.61
НӨАТ-т төлсөн		19,243,182.50
Даатгалын төлбөрт төлсөн	230,320.00	115,830.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	70,979,405.28	-2,113,934.28
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0
Мөнгөн орлогын дүн (+)		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	0
Биед бус хөрөнгө борлуулсны орлого	0	0
Мөнгөн зарлагын дүн (-)	-1785100	6,898,282.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-1185100	6,898,282.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-600000	0.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		



Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн “Армоно корпораци” ТӨААТҮГ-ын
2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зээл авсан,өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		0
Төрөл бүрийн хандив төсөл	39800000	0
Мөнгөн зарлагын дүн (+)		0
Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		0
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		0
Төлсөн ногдол ашиг		0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-102,062.93	-9,012,216.28
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	145700.45	11,471,516.38
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43637.52	2,459,300.10

